

2



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 206 207 210 213 тоот
7-р баг Сайнцагаан сум Дундговь аймаг 48090
Утас 70592439, 70592208, 70593208
И-мэйл dundgovi@audit.gov.mn

2023.10.11 № 02/166

танай _____ -ны № _____ -т

**ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.АРИУНАА ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, зарцуулалт, захиалагчийн хяналттай холбоотой зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлж байна.

Акт, албан шаардлагыг хэрэгжүүлж, зөрчлийг арилган, заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт..... хуудас

ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

0012032671



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 223 А/270318

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Орон нутгийн хөгжлийн 2023 оны эхний жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Говь-Угтаал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгөөр хийгдсэн 4 төрлийн 120,332,621 /Нэг зуун хорин сая гурван зуун гучин хоёр мянга зургаан зуун хорин нэгэн/төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, тайланд тусгуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 –д /Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.2.-т /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага./, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 30 дугаар тогтоолын “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2 /Орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу орон нутгийн өмчийн газарт тавьж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ/, 4.8-д /Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн төрийн өмчийн байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээр хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг Орон нутгийн өмчийн газарт нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ/ заасныг;

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөрөнгүүдийг холбогдох хууль, журмын дагуу холбогдох байгууллагуудад орлого авахуулж, бүртгэл тайланд тусгуулах ажлыг зохион байгуулах;

Зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 12 дугаар 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг дарга Т.Ариунаа, Засаг даргын орлогч Б.Даваасүрэн, санхүү албаны дарга Н.Ганбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР



Д.ДОЛЖИНСҮРЭН

БАТАЛГААЖУУЛСАГ

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113


ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 225 А/270318

Мандатгүй

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитаар **270,670,800 /Хоёр зуун далан сая зургаан зуун далан мянган найман зуун/** төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сангийн хөрөнгийг сумын зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдоогүй **270,670,800 /Хоёр зуун далан сая зургаан зуун далан мянган найман зуун/** төгрөгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталж санхүүжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5-д *батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*; 60 дугаар зүйлийн 60.3-т *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно*, 60.3.1-д *орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ*, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.3.3.-т *ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх*; / заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11.-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөж зарцуулахгүй байх, хууль журмыг мөрдөж ажиллах;
2. 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийхээр батлагдсан зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх

0012042043

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Говь-Угтаал сумын Засаг дарга Т.Ариунаа, Засаг даргын орлогч Б.Даваасүрэн, Санхүүгийн албаны дарга Н.Ганбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР  Д.ДОЛЖИНСҮРЭН

БАТАЛГААЖУУЛСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Р.МӨНХТОГТОХ



¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

